

«ХӨӨРХИЙ ЗАЙЛУУЛ, ИЖИЙ МИНЬ ...» ГЭДГЭЭС ҮҮТГЭЖ ...
(Үг хэллэгийн амь амьдрал, соёл хэрэглээ)

Б.Пүрэв-Очир¹

Хөөрхий зайлуул, яаж

Хомроостэй нэг малгай дор

Хөгшин, залуу Сампил

Хотлолцон явсан байнам? (Д.Нямаа:

«Сампил» шүлгээс)

Монгол хүн “хөөрхий”, “эвий”, “зайлуул”, “чааваас” ... г.м. аялга үг болон уулгалах үгийг яагаад хэлдэг юм бол? Ийм үгс хүний сэтгэл зүрхнээс унадаг юм болов уу? Оюун тархинаас нь гардаг юм болов уу? Өгүүлэх нь:

“Хөөрхий”, “хөөрхийс”, “хөөрхий зайлуул”, “зайлуул даа, хөөрхий”, “эвий хөөрхий”, “хөөрхий ээ”, “хөөрхий чааваас”, “зайлуул” г.з. монгол хүмүүний өр нимгэн сэтгэлийн угаас гардаг, хүмүүн хоорондын ойрын ба холын харилцааны зөрлөг дээрх үнэлэмж, сэтгэлийн өнгө аясыг илэрхийлдэг цөөнгүй үгсийг өвгөд дээдсийнхээ амнаас унахыг сонсож явжээ.

Монгол хүн өрөвч сайн сэтгэлийн ийм аялга-сул үгсийг хэзээ, хаана, хэнд, юуны учир уулгалан хэлдэг, тэр нь хэл-сэтгэхүй, нийгэм-соёлын болон хэрэглээний ямар үндэстэй байдаг бөгөөд ямаршуухан мэдлэг-мэдээллийг зөөж тээж уламжилж ирсэн бэ? гэдэг бол судлаад, сонирхоод үзмээр асуудал юм. Даан ч монгол хэлний хандлага үг, аялга үг, уулгалах үг, хараал зүхэл үг, сул үгсийн “хүүдий”-г монгол хэлшинжлэлтэн, утга соёлын судлалтан нар олигтой судалсангүй, ерөнхийд нь орхигдуулж ирж, хөөрхийс! Ийм үгсийн нууц уурхай, эрдэнэсийн сан бол найруулга, хэрэглээний машинд чухал түүхий эд болдог учиртай билээ.

Орон зай, цаг хугацааны талаас нь тандаж ажиглавал, хүмүүний сэтгэл зүрхний дотоод чинадаас дуурсан гардаг «хөөрхий зайлуул, ижий минь ...» маягийн уулгалах хандлага үгсийг нэг талаас, гол төлөв ахмад буурлууд, аав ижий, хөгшин хөвөө, ядарсан зүдэрсэн хэн нэгэнд, эсвэл, нөгөө талаас, нялхас балчирс, өнчид өрөөсөнчүүл, алдсан эндсэн хэн нэгэнд, бас тэрчлэн амьд байгаль, ургамал цэцэгс, адгуус амьтад тэдгээрийн үр төл тэргүүтэнд холбогдуулан хандаж, хэл яриандаа оруулж хэрэглэдэг байгаль, нийгэм-соёлын уламжлалтай байж. Гэхдээ хэнд ч, юунд ч хандаж, яаж ч уулгалсан, ямар өнгө аяс, үнэлэмжийг илэрхийлсэн ч ойр дэргэдээс нь, эсвэл, улаан нүүрэн дээр хэлэх нь бас ч хорио цээртэй. ховор цөөн байсан нь сонин байна. Өөрөөр хэлбэл, монгол хэлний аялга үг-өгүүлбэрийн хүнээс өөрийнх нь сэтгэлээс хамаарах

1. Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Б.Пүрэв-Очир

тал хийгээд танихуйн хэлшинжлэлийн өнцгөөс ажваас, тийм маягийн үг-өгүүлбэрийг ярианд болон бичигт харилцааны зөрлөг, ямар нэгэн "зайц" -аас хэлдэг, бичдэг, дамжуулдаг нь учир начиртай юм байжээ.

Монголчуудын өрөвдөхүй, өхөөрдөхүй, хайрлахуй, харамсахуй, санагалзахуй, багасгахуй, басамжлахуй, эрхлүүлэхүй, энхрийлж эвийлгэхүйн арга, билгийн ухаанд:

«Магтах үгийн далд нь сайн»,

«Эвий ихэдвэл эрхлүүлэхийн цондон»,

«Хөөрхий олишрвол хүндлэл багасдаг»,

«Хайр нь дотроо, хал нь гаднаа»,

«Худалч хүн хоорхий олон, хууралч хүний эвий олон» г.м. үг хэллэг уламжилсаар ирсэн нь учир жанцантай аж.

Өдгөө ингээд бодоход, хөөрхий бидний эрчүүд, хүмүүжихийн зам мөрийг олж, хорвоотой танилцахдаа амьд сайхан ярианд, анх *«хөөрхий зайлуул, ...»*-ийг эмээ өвөө, ээж аавынхаа амнаас сонсож явсан бол, хожимхноо сургууль соёлын босго алхаж, бичгийн хэлтэй золгонгуутаа эрдэмтэн-зохиолч Цэндийн Дамдинсүрэн гуайн *«Буурал ижий минь»* (Ленинград, 1934) шүлгийг уншиж байж л *«хөөрхий зайлуул, ...»*-тай танилцаж эхэлж л дээ.

«Буурал ижий минь» шүлэгт:

«Хөөрхий зайлуул, ижий минь

Хоориоож намайг харахлаар

Муу бүгдийг сайн болгож,

Муухай бүгдийг сайхан болгож,

Тагжгар туранхай биеийг минь

Мантайчсан тарган гэх юм,

Тахлай хөх нүүрийг минь

Мантайчсан цагаан гэх юм ...» гэж дүрсэлсэн байдаг бөгөөд *«Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас эрдэм өвөртөлж ирэхээр зорьсон»* (Д.Нацагдорж) хүний хүү, нүүдэлчдийн эх нугагтаа хоцорсон буурал ижийгээ санагалзан байж:

Ховоорон харагдах хондийн замаар

Хохрон бүрэлзэх мананы дундуур

Хөндөлсөн байх уулсын хотлоор

Ховолзон нүүх үүлсийн доогуур

Өглөө үдэшгүй саравчлан харж,

Өдөр шөнөгүй санаашран шаналах ...»

буурал ижийгээ хайрлан өрөвдөж, *«Хөөрхий зайлуул, ижий минь ...»* гэж уулгалан хандсан байдаг.

Монгол хэлний *«Хандсан үг-өгүүлбэрийн»* үүрэг, утга, хэрэглээг зуу гаруй зохиолч, сэтгүүлчдийн бүтээл дээр судлаад, баримт сан бүрдүүлээд үзсэн чинь «ижий»-дээ, «эх хүнд» хандсан үг, уулга алдсан үг, дуудах өгүүлбэр, тэр олон зүйл хандлагын дотроос бараг 60 хувийг эзэлж байгаа нь ч сонирхол татаж байна.

30-40-өөд оны үед эрдэм боловсролын мөр хөөж, алс газар сураар одсон Ц.Дамдинсүрэн

Б.Пүрэв-Очир

тэргүүтэн нь эх үрсийн элбэрэл журмыг сахиж, буурал ижийгээ санагалзанхан, нүүдэлчдийн соёл-сэтгэлгээтэй амин холбоотой аялга-хандлага үгсээр ийнхүү дүрсэлж байсан бол, орчин цагийн уран зохиолд тэрхүү баймж, үнэлэмж, өнгө аяс нь бүр ч олон шинэ хэлбэр, агуулгатай болсон нь илт харагддаг. Энд баримт болгож, нэгэн найрагчийн Уул-Алтайдаас ч юмуу, эсвэл Сэлэнгийн шар тохойгоос ч юмуу, аль эсвэл хялгана най асан Дорнодын уудам талаас ч юм уу, бүр эсвэл Заг-Байдрагийн Хүрэн бэлчирээс ч юм уу «Хяруу унах цаг»-аар ээжийгээ санагалзсан сэтгэлийн өчил шүлгээс жишээ татаж, харьцуулан сонирхъя:

Хяруу унахад ээжийгээ саналаа.

Хялганын аясаар бөхөлзсөн ээж минь дээ,

Анхны цаснаар ээжийгээ саналаа.

Асгарсан сар шиг гэрэлтэй ээж минь дээ,

Газрын наран таны хаа хайрын элчинд

Галын бурхан шиг өслөө, хүү чинь ... (Лханаагийн Мөнхтөр: «Жаргалын найман морь», II боть, 2012 номоос) гэж бичиж, ханджээ.

Хүний үр төдийгүй, мал, амьтны үр төл, зулзага хүртэл “эхийн усан өлгий”-өөс хөрст дэлхийд унамагцаа «ээж ээ ...» гэдэг юм болов уу, эсвэл «сүү-хоол» гэдэг юм болов уу? Тийм нэгэн утгатай авиа гаргаж, “уйлдаг”, “майлдаг”, “гийнэдэг” байж магад бөгөөд тэр нь нэг насны амь амьдралд нь хичнээн ч удаа давтагддаг юм, бүү мэд! Сэтгэц шинжлэлтнүүд, энерги судлаач нар үүнийг сонирхдог байна. Зохиолчид, сэтгүүлчид түүнийг маш сонин мэдрэмжтэй дүрсэлдэг байна. Тухайлбал, зохиолч-сэтгүүлч Банзрагчийн Цэрэнжамц «Гөлөг» хэмээх шүлэгтээ:

Гөлөгний дуун агаарт тэнэнэ.

Эхийгээ эрнэ.

Өөрийн минь эх үү! гэж нохдын дууг чагнана.

Өнгөрсөн болгоны осгийг үнэрлэнэ.

Тэгтэл,

Ижийгий нь үнэр ханхалсан зүс нь ижил гутал

Илбийн үзэгдэл мэт урд нь ирлээ.

Эрүүгээн дэвсэн эрхлэх нялх голөгний дуун

«Ээж ээ!» гэх шиг хахиртан тасалдав ...

Ошиглуулжээ, хөөрхий! ... гэж дүрсэлсэн байх юм. Тун сонин санаа биш гэж үү?!

Монгол хэлний «ээж ээ ...», «ижий минь дээ ...», «хөөрхий ээж минь ...» гэдэгтэй «зайлуул» гэдэг үгийг элэг бөөрөөр нь нийлүүлж, эвцэлдүүлэн хоршиж хэлдэг, бичдэг нь тун учиртай бололтой. Хэлж ярьж байгаа, бичиж найруулж байгаа зүйлд маш өвөрмөц үнэлэмж илэрхийлдэг, баймж утга оруулдаг, өнгө аяс нэмдэг, сэтгэлийн хөдөлгөөн, хандлага илтгэдэг, бас холбох гагнах арга хэрэглүүр болдог энэхүү “зайлуул”-ыг хэзээ, хаана, хэн, ямар зорилгоор хэрэглэснийг хэлний баримтаас харахад сонин. Албан хэрэг болон эрдэм шинжилгээний найруулгад “зайлуул”-ыг хэрэглэсэн тийм «хачин хүн» одоогоор алга. Сонин нийтлэлийн найруулгад өдрийн од шиг тохиолдоно. Харин ярианы болон урансайханы найруулгад тун өвөрмөц хэрэглэгддэг, хүмүүн хоорондын харилцаа, сэтгэлийн дотоод чинадын торгон зөрлөг, зайц дээр л амнаас унадаг «уулгалах үг» ч гэмээр онцлогтой юм. Тийм жишээ, ийм амьд яриаг өд төдийгөөр нь хэлдэг сайхан уламжлал байлаа:

Б.Пүрэв-Очир

- Та намайг нэлээд тулгаж байна аа даа. Зөв өө. Сэтгүүлч хүний онцлогийг мэднэ ээ. Төмөр-Очиртой Шинэ хүчний дээд сургуульд багшилж байхдаа танилцсан. Их ч шударга, их ч юм мэддэг. Энэ чанараараа та нарын хэлдгээр бол, од болсон хүн дээ, **зайлуул!** (С.Жалан-Аажав: «Түүхийн хуудаснаас үнэнийг арчин устгаж болохгүй.» Зохиолч-сэтгүүлч До.Цэнджавын «Он цагийн шашдир», 2010 номоос. 1993, «Засгийн Газрын мэдээ» сонинд нийтлэгдсэн ярилцлага ...);

... Харин одоо яагаад ч юм бэ, эргэн тойрны уулс чимээгүй дүнсийнэ. Нүдний аягаар нулимс дүүрч цийлэлзэнэ. **Хөөрхий дөө, зайлуул.** Дулмаа гуай! (Дан.Нямаа: «Нарны алга» дууль, 2010 номоос);

... Жигжид их ядуу, харин учиргүй уран хүн байсийм. Уг нь манай нутгийн хүн. Хөдсөн Жигжид гэдгийм. Ерөөсөө тийм их ядуу, нэг муу хохь тайж хүн. Хохь тайж хүний хүү юм. Тэгээд заримдаа бид нүцгэн Жигжид тойн гэдэгсэн. Тойноо алд даа, юу ч байхгүй хоосон юм чинь, **зайлуул!** (Жамцын Баяраа: «Их дуучны яриа буюу алдар гавьяат дуучин Магсархурцын Дугаржавын яриа» УБ., 2009, номоос)

«Эртний сайхан»-ыг бол над хэн ч заагаагүй. Жунай гуай л ганц нугалаа заасан. Дашрэнчин гуайн дүү. 30 жилийн ойн наадмаар Жунай гуай манайд ирж буусан юм. Ингэж олон уулзаж байхдаа надаар дуулуулаад, заримдаа уйлаад байдаг юм, **хөөрхий зайлуул...** (Мөн номоос) г.м.

Барим тавим энэ сайхан баримтуудаас ажиглахад, монгол хүн, нүдээр харж, чихээр сонсож, биеэр хүрэлцэж, сэтгэлээр амталж, гараар барьж мэдрээд л эл торгон агшинд, харилцахуй мэдрэхүйн тэр зайц зөрлөг дээр л «Зайлуул», «Хөөрхий зайлуул», «Эвий зайлуул»-ыг хэлж дуун алддаг, уулгалдаг байна. Иймээс “зайлуул”-ыг таалалт зэрэг, эс таалалт сөрөг үнэлэмж, сэтгэлийн хөдөлгөөн илтгэдэг “оруулбар” нэгж гэж үзэж болно.

- Монгол хэлний “зайлуул” гэдэг үг яаж бүтсэн бэ, ямар аймгийн үг вэ, ямар утга, үүрэгтэй вэ, хүн яагаад энэ үгийг хэлдэг вэ, ямар эрчим долгионтой вэ, ямар ямар үгтэй ойр дэргэдийн “явдаг” вэ? гээд л зарим сурагч оюутан, магистр, хэл судлаач нараас асууж цохилдуулж үзлээ л дээ.

- Хачин юм! Зарим нь «Зайл! гэсэн үг» гэж байна. Зарим нь «хөөрхийлсэн, эвийлсэн л үг» гэж байна. Бүр зарим нь ямар ч аймагт оруулж боломгүй «хачин зайгуул үг» гэж байна. Бас зарим нь «Энэ бол монгол хүний уулгалах аялга үг байх.» гэж байна. Бас нэг хоёр нөхөр «Манай залуучууд энэ үгийг бараг хэлэх, хэрэглэхээ байсан ш дээ!» гэж байна. Гэтэл нэг нөхөр: «Ээжтэй болгон л, эгээрч гэгээрсэн болгон л хэлдэг байх даа ...» гэж байна.

Энэ нь юу харуулж байна вэ? гэхлээр үг-утга бүрийн цаана үзэгдэх / эс үзэгдэхүй, сонсогдох / эс сонсогдохуй, хүртэгдэх / эс хүртэгдэхүй, ойлгогдох / эс ойлгогдохуй, ухагдах / эс ухагдахуй оршдог бөгөөд тэр нь хүмүүний сэтгэлд сүлэлдэн байдаг гэдэгтэй холбоотой юм.

Олон ургальч үзэл! Олон эшт санаа! Энэ цагийн өнгө! Энэ нь зөв, тэр нь буруу, ийм тийм гэж дүгнэмээргүй санагдав. Мөхөс миний бие. «Зайл! гэсэн үг» гэдгийг хамгийн зөв хувилбар, оновчтой хариулт гэж бодоод мунгинаад байна. Яагаад гэвэл, «Эхийн санаа үрд, Үрийн санаа ууланд!» гэдэг монгол ухааны үг орой руу орж ирээд байх шинг. Бас бидний монголчуудын эх хэл, утга соёлын боловсрол ингэтлээ их доройтож, уламжлалаа уландаа гишгэж, хүнийрхэн хүйтэрч байгаагаас сөрөг үнэлэмжит муу үг, хараал зүхэл үг, этгээд бүдүүлэг үг, харь хэлний үг, самбар лоозонгийн магтаал үг, нохой ам нийлүүлсэн таримал зохиомол үг хэллэг (“ШАГ”, “МАНАН”, “ГЕНСЕК”, “НАН” г.м.) тоо тоймгүй олширч байгаа энэ цөвийн цагт иймэрхүү хариулт «Зөв» байлгүй яахав гэж бодно. Үүнийг үл өгүүлэн, өгүүлэх минь:

Б.Пүрэв-Очир

Гэвч бидний мэдээлэлд сонирхож байгаа «зайлуул» гэдэг энэ сайхан монгол үгийг ганцааранг нь битгий элдэж хөөгөөрэй! Хүн хүнийхээ дэмэнд, загас усныхаа хүчинд явдаг шиг, үг, үгийнхээ эрчимд явж, амь орж, эрчим долгион нь түгэж байдаг юм. «Уугуул нутаг», «суугуул монгол», «гүйгүүл морин», «харуул занги», «босуул бүсгүй», «алдуул мал», «засуул өвгөн», «хэсүүл хүүхэд», «тавиул мал», «сөргүүл үг», «хэвтүүл цэрэг», «зайгуул үг», «зайлуул нжий ...» гэх зэрэг өдий төдий үгийн бүтэц, утга, эрчим долгион, соёл хэрэглээ, мэдээлэл-мэдлэгийн дотор нэг эргэцүүлээд үзээрэй. Таны хэл, соёлын боловсролд нэмэр тустай байж магад. Эс тэгээд болохгүй бол, яруу найрагч, сэтгүүлч Дан.Нямаагийн:

Гүйгүүл морин

Зургаан сардаа тууламгүй

Нүүгүүл уулс

Зуны сардаа барамгүй

Нисүүл шувуун

Найман сардаа тууламгүй

Хэсүүл салхи

Намын сардаа барамгүй ... «Тал минь, тавиухан цэнхэр тал минь» хэмээх шүлгийн мөрийг нэг уншаад, «-уул, -үүл»-тэй болгоныг нэг аялгуулаад үзээрэй. “Зайлуул” гэдэг монгол сайхан үгийн маань утга учир нэг олдох болно доо, хөөрхий! Бас учир утгыг нь олж хэрэглээд, «уулга алдсан үг» гэж хэлсэн авъяас билэгт зохиолч ч байна. Жишээ нь:

Замын-Үүд !

Зайлуул даа, хөөрхий! гэж монгол сэтгэл уулга алдана.

Заяа тавилангийн ямар харгуй-уулзвар дээр

Замын-Үүд бид хоёр бүртэлсэн байнам? гэж МУСГЗ Н.Даваадаш бичсэн нь найрагчийн сэтгэлээс л гарчээ дээ. («Аяны таталбар» (1982) шүлгээс)

Төгсгөлд тэмдэглэхэд, эх хэлний үг-утгын санд муу муухай үг хэллэг гэж огт байдаггүй, харин муу хэрэглэгч л гэж байдаг аж. Эх бичвэр, өгүүлбэрийн дотор ямар ч “үг” нь орон зайцаа олж байрлаад, өнгө аяс нь нийцрээд, амь ороод, эрчим долгион нь зохироод ирэхийн цагт утга, соёлыг тээгч, мэдлэг-мэдээллийг дамжуулагч болдог жамтай. Нэг үгээр жишээ татаж харъя. Монгол хэлний “чааваас” гэдэг үг бол тийм ч идэвхтэй хэрэглээний үг биш, төрөл бүрийн найруулгад тохируулж, онож хэрэглэхэд амаргүй үг юм. Гэтэл уг эх, сэдвийн санаанд нь зохилдуулаад, зөв хэрэглэвэл хөөрхий энэ аялга-үг ямар ч сүрхий нэр үг, үйл үгээс дутахгүй, тийм зохист өнгө аяс, үнэлэмжийг илтгэж чадна. Монгол улсын анхны ардын уран зохиолч, Цэндийн Дамдинсүрэн «Хоцрогдсон эмгэнийг сурвалжилсан тэмдэглэл» (1974) дээ:

- Энэ шилийг эргүүлнэ, амсар нь хэний өөдөөс харвал тэр хүн авьяасаа үзүүлнэ гэв. Тэгээд шилээ нилээд хүчтэйгээр нар зөв эргүүлээд орхив. Шил, эргэлдэж байгаад, эргэхээ болив. Амсар нь нөгөө бөтөр эмгэний өөдөөс хараад зогсов. «Ай, чааваас, хөөрхий энэ эмгэн одоо яадаг бол?» гэж би төлөөнөөс нь зовж байв ... гэсэн өгүүлбэрт «Ай, чааваас, хөөрхий ...»-г ёстой нэг онож хэрэглэсэн байдаг. Энэ зохист найруулгад байгаа «Ай, чааваас, хөөрхий ...» нь их зохиолчийн мэдрэхүйгээс гарав уу, аль эсвэл сэтгэхүйгээс гарав уу?!, ямар мэдээлэл тээж байна вэ? гэдэг нь бас сонин зүйл.

Нэрт сэтгүүлч, нийтлэгч Цэрэндоржийн Балдорж: «... Мэдээллийг цуглуулах, түүндээ дүн шинжилгээ хийх, түгээх мэдээллийнхээ хэв маяг, дүрийг гаргах, алдаа мэдгийг нь нягтлан үзэх, тов тодорхой, ойлгомжтой мэдээллийг олон нийтэд аль болох шуурхай хүргэх ..., гэхдээ үүнийг

Б.Пүрэв-Очир

сэтгүүлч бүр хэрэгжүүлж чадахгүй байна. Энэ нь сэтгүүлчийн өөрийн нь торгон мэдрэмж, туршлага, мэдлэг, ёсзүйн чадамжтай салшгүй холбоотой. ... Аливаа мэдээлэл нь мэдлэг юм. Учир нь мэдлэгийн түвшин, мэдээлэл цуглуулсан багтаамж хүн бүрт өөр өөр байдаг ... Манай улсын нэрийг «Монгол» эсвэл, «БНМАУ» биш, «Монгол улс» гэх нь хүртэл шинэ мэдлэг, мэдээлэл болох жишээтэй ... Энэ утгаар нь авч үзвэл, сэтгүүлчийн бичсэн үг үсэг, хэлсэн үг болгон нь мэдлэг тээж явдаг ...» (Ц.Балдорж: «Сэтгүүлзүйн нийтлэг үүрэг, түгээмэл зарчмын тухай» өгүүлэл, «Далай ээж маань цаазын тавцанд» номоос, Уб., 2008, 10-р тал, эмхтгэсэн Н.Шүр, Р.Чулуун) гэж бичиж үлдээсэн байдаг. Нээрээ л үнэн дээ. «Ар Монгол» гэх үү, «Монгол улс» гэх үү?; «Аралын Япон» гэх үү, «Япон улс» гэх үү? гээд л ёсзүй, геополитик, утга, соёл, мэдээ-мэдээллийн нарийн учир, өвөрмөц ялгаа байдаг.

Эцэст хэлэхэд, дуун ухаантан, үгийн утгач Агванхайдав «Үгийг найруулна гэгч үйлдэхүйе» бэрх үзэсгэлэнт чимэг мөн, утгыг найруулна гэгч уйдал үгүй анхааран авахын ёсон мөн» гэж айлдсаныг хэлийг хэрэглэгч хүн болгон машид анхаарууштай юм.

Номзүй

1. Бат-Ирээдүй, Ж., «Монгол хэлний ерөөл бэлгэ, хараал зүхэл үгийн сан», «Зөв зам» books, Мон-Эдюкшн Пресс Пабблишинг, Уб., 2009 он.
2. Бямбасан, П., «Монгол хэлний сул үгийн хүүдийг шинжлэх нь» МУИС-ийн Монгол хэл-Соёлын сургуулийн «Монгол судлал» ЭШБ., Уб., 2007 он.
3. Дамдинсүрэн, Ц., Бүрэн зохиол, Тэргүүн боть, Удиртгал, тайлбар сэлт үйлдэж хэвлэлд бэлтгэсэн Д.Цэдэв, Уб., 1998 он.
4. Мөнх-Амгалан, Ю., «Орчин цагийн монгол хэлний баймжийн ай», МУИС, Монгол судлалын дээд сургууль, нэмэн заеварласан хөөр дахь хэвлэл, Уб., 1998 он.
5. "Орчин цагийн монгол хэлний үгзүйн байгуулалт". ШУА, Хэл зохиолын хүрээлэн, хамтын бүтээл, Тэргүүн дэвтэр, Нэр үгсийн аймаг, Уб., 1987.
6. Пүрэв-Очир, Б., «Үг, өгүүлбэрийн амьдрал араншин, эрчим энерги, соёл хэрэглээ», 7-р дэвтэр, Уб., 2009 он.
7. Пүрэв-Очир, Б., «Үг, өгүүлбэрийн амь амьдрал, эрчим долгион, соёл хэрэглээ», 8-р дэвтэр, Уб., 2011 он.
8. Пүрэв-Очир, Б., «Цэндийн Дамдинсүрэн болон түүний ...», 9-р дэвтэр, Уб., 2012 он.
9. Цэнджав, До., «Он цагийн шашдир», Уб., 2010 он.